



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

20d5 оны 02 сарын 05 өдөр

Дугаар A/25

Шивээговь сум

Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухайн хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2, 38 дугаар зүйлийн 38.4, Иргэний хуулийн 515 дугаар зүйлийн 515.2, 535 дугаар зүйлийн 535.1 дэх хэсгийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Боржигин овогт Долгорсүрэнгийн Намхай (ЕЙ45062016) нь нас барсан тул Шивээговь сумын 1 дүгээр баг, 10 дугаар байрны зүүн талд байрлах 21 м² "Автомашины гараж"-ийн зориулалттай газрын газар эзэмших эрхийг хуулийн дагуу өвлөх эрхтэй Боржигон овогт Гончигийн Бямбасүрэн (ЕЙ51052005)-д "Автомашины гараж"-ийн зориулалтаар 15 жилийн хугацаагаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Хуулийн дагуу эзэмших эрхийг өвлөх эрхээр шилжүүлэн авч буй газрынхаа орчны тохижилтыг сайжруулж, зүй зохистой ашиглахыг иргэн (Г.Бямбасүрэн)-д үүрэг болгосугай.

3. Газар эзэмших эрхийг өвлөх эрхээр шилжүүлэн авч буй иргэн Г.Бямбасүрэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Т.Өлзийбуд)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2011 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн А/138 дугаар захирамжийн 18 дахь бүртгэлийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Ч.СУГАРМАА

